



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/446

Зуунмод

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэсант сумын уугуул Нэргүйн Дашдаваа нь Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101, Төв аймгийн 99, Зуунмод хотын 80, Монгол Улсын дөрөв дэх Ерөнхий сайд Манзушир хутагт Самбадондовын Цэрэндорж, Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Шадар сайд, бүгд захирах сайд, Дотоод Яамны хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайд, Да лам Гомбын Цэрэнчимэд нарын мэлмий гийсний 150 жилийн ойн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд түрүүлж аймгийн “Арслан” цол хүртсэн тул хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 1,100,000 (нэг сая нэг зуун мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, Төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, шилэн дансанд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

